



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 07 сарын 31 өдөр

Дугаар А/65

Улаанбаатар хот

“Улаанбаатар фүүд фестиваль”
арга хэмжээ зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 01/19 дугаар тогтоолоор батлагдсан Нийслэлийн Эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 1-49, Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/673 тоот захирамж, тус газрын дүрмийн 2.5.3, 3.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол хоолны соёлыг гадаад, дотоодын жуулчдад таниулах, гадаадын жуулчдад зориулсан арга хэмжээний тоог нэмэгдүүлэх, аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг нэмэгдүүлэх зорилгоор “Улаанбаатар Фүүд Фестиваль” арга хэмжээг 2018 оны 8 дугаар сарын 25, 26-ны өдрүүдэд Сүхбаатар дүүрэг 3-р хороо, Сөүлийн гудамж /Гэрэлт гудамж/-д зохион байгуулсугай.

2. “Улаанбаатар Фүүд Фестиваль” арга хэмжээг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, зохион байгуулах бэлтгэл ажлын төлөвлөгөөг хоёрдугаар, шаардагдах төсвийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах төсөв 13 270 000 /арван гурван сая хоёр зуун далан мянган/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч /Б.Батбаатар/-д зөвшөөрсүгэй.

4. Арга хэмжээний үеэр хамтран ажиллах, гэрээ байгуулах байгууллагуудыг судалж, 2018 оны 08-р сарын 25-ны өдрөөс өмнө танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч /В.Батчимэг/-д даалгасугай.

ДАРГА



Д.БАТСҮХ

1150500211

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2018 оны 07
сарын 31 өдрийн А/65 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

5284325 СБТ 8936 1118263502

“Улаанбаатар фүүд фестиваль” зохион байгуулах
ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч:

В.Батчимэг - Бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын
үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд:

Б.Ербахыт - Статистик, сургалт, судалгаа хариуцсан
мэргэжилтэн

Н.Алтанзаяа - Хөгжлийн бодлого хариуцсан мэргэжилтэн

Э.Зоригт - Маркетинг, мэдээлэл сурталчилгаа
хариуцсан мэргэжилтэн

Г.Азжаргал - Олон нийтийн харилцаа хариуцсан
мэргэжилтэн

Нарийн бичиг дарга:

Б.Ишдорж - Дотоодын аялал жуулчлал, бүтээгдэхүүний
хөгжил хариуцсан мэргэжилтэн

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2018 оны 07
сарын 31 өдрийн А/65 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

5284025 СБТ-8926 1118203502

“Улаанбаатар фүүд фестиваль”
зохион байгуулах бэлтгэл ажлын төлөвлөгөө

№	Хийгдэх ажил	Хугацаа	Хариуцах ажилтан	Хамтрах байгууллага, ажилтан
1	Засаг даргын захирамжийн төсөл боловсруулж, батлуулах	2018.07.19- 2018.08.25	Б.Ишдорж	Хамтран ажиллах байгууллага
2	Газрын даргын тушаалын төсөл боловсруулж, батлуулах			
3	Хамтран ажиллах гэрээ байгуулах			
4	Арга хэмжээнд холбоод, байгууллагуудыг оролцуулах	2018.07.19- 2018.08.26	Н.Алтанзаяа	Хамтран ажиллах байгууллага
5	Арга хэмжээний баннер хэвлэмэл хуудасны загвар гаргах	2018.08.01- 2018.08.26	Э.Зоригт	Хамтран ажиллах байгууллага
6	Арга хэмжээг сурталчилсан видео шторк хийлгэх, сурталчилах	2018.08.01- 2018.08.26	Б.Ишдорж	Хамтран ажиллах байгууллага
7	Арга хэмжээний талаар мэдээ бэлтгэж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилах	2018.08.01- 2018.08.26	Г.Азжаргал	Хамтран ажиллах байгууллага
8	Тайз дэлгэц, хөтлөгч, урлагийн тоглолт зохион байгуулах	2018.07.19- 2018.08.26	Б.Ишдорж	Хамтрах ажиллах байгууллага

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2018 оны 07
сарын 31 өдрийн А/65 дугаар
тушаалын гуравдугаар хавсралт

5284025 СБТ 2026 1118263562

“Улаанбаатар фүүд фестиваль”
төсвийн задаргаа

2018 оны 7 дугаар сарын 31

Улаанбаатар хот

№	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн
1	Тайз карказ, Лед дэлгэц, Хөгжим апаратыр, Тайцны гэрэл	ш	2 өдөр	2,500,000	5,000,000
2	Асар түрээс	ш	5*2 өдөр	50,000	500,000
3	Сурталчилгааны видео шторк бэлдэх	-	-	1,200,000	1,200,000
4	Баннер урилга стэнд хэвлэл	-	-	300,000	300,000
5	Шилдэг тогооч /аж ахуйн нэгж/ шалгаруулах уралдааны шагнал	хүн	2	800,000	1,600,000
6	Хөтлөгч	хүн	2 өдөр	750,000	1,500,000
7	Амьд хөгжмийн хамтлаг, дуучид	хүн	2 өдөр	1,000,000	2,000,000
8	Бүжгийн үзүүлбэр	хүн	2 өдөр	200,000	400,000
9	Косплей тэмцээний шагнал	хүн	2 өдөр	250,000	500,000
10	Бургерийн тэмцээний шагнал	хүн	2	20,000	40,000
11	Зайрмагны тэмцээний шагнал	хүн	2	20,000	40,000
12	Хот догны тэмцээний шагнал	хүн	2	20,000	40,000
13	Гэр бүлийн тэмцээний шагнал	хүн	3	50,000	150,000
НИЙТ					13,270,000